

**“МОНГОЛ УЛСАД АГААРЫН ХӨЛГИЙН ТҮЛШ НИЙЛҮҮЛЭХ ТУХАЙ МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР” БОЛОН ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ПРОТОКОЛЫН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр “Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр хүргүүлсэн байна.

Төсвийн байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу дээрх хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Хэлэлцээрт өөрчлөлт оруулсанаар Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын хамтын ажиллагаа газрын тосны салбарт өргөжиж, агаарын хөлгийн түлшний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартын шаардлагад нийцсэн шатахууныг тогтвортой, хямд үнээр нийлүүлэх боломж бүрдэх бөгөөд тус хэлэлцээрийн 10 дугаар зүйлд заасны дагуу дээрх хэлэлцээрт өөрчлөлт оруулах протоколын төслийг боловсруулж, өөрчлөлтүүд тусгасан байгаа тул Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцүүлж, холбогдох шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хэлэлцээр болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлсэн болно.

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” болон түүнд өөрчлөлт оруулах протоколын төслийн зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР